**НИЙСЛЭЛ ДЭХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул “Зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/003/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | НТАГ-ын дэд дарга Ч.Болд<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br>СНАХ-ийн дарга: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас:315558 Цахим хаяг:gantugss@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг<br>Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/296

танай ______________-ны № ______________-т

ХАН-УУЛ ЗАМ ЗАСВАР
АРЧЛАЛТ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.ГАНБАДРАХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-Уул Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хан-уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ нь тайлант онд орон нутгийн төсвөөс 13,246.9 сая төгрөг, Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар гүйцэтгэсэн ажлын санхүүжилтэд 550.9 сая төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 40.0 сая төгрөг, бусад орлого 94.6 сая төгрөг, нийт 13,932.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,179.3 сая төгрөгийн зардал гарч, 246.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлага болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудал**

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\Erdenimaa.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025 03 14 HUD AZZA.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,249,956,999.04** | **1,206,307,254.26** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | **169,202,925.98** | **499,192,085.06** |
| 312 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 169,202,925.98 | 499,192,085.06 |
| **33** | **Дансны авлага** | **72,702,804.39** | **326,313,314.39** |
| 33.1 | Татвар, НДШ-ийн авлага | 72,570,804.39 | 292,988,187.39 |
| 33.2 | Орон нутгийн авлага | 132,000.00 | 33,325,127.00 |
| 34 | Урьдчилж гарсан зардал | 624,449,608.95 | 125,461,740.00 |
| 34.1 | Бараа материал | 383,601,659.72 | 255,340,114.81 |
| **39** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,708,849,675.54** | **1,789,976,596.47** |
| 392 | Үндсэн хөрөнгө | 1,708,668,738.13 | 1,789,976,596.47 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 180,937.41 | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,958,806,674.58** | **2,996,283,850.73** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,762,316.00** | **-** |
| **41** | **Богино хугацаат өр төлбөр** | **9,762,316.00** | **-** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,562,616.00 | - |
| 41430 | Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого | 5,199,700.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,949,044,358.58** | **2,996,283,850.73** |
| 51 | Засгийн газрийн хувь оролцоо | 2,949,044,358.58 | 2,996,283,850.73 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 738,735,000.00 | 1,055,003,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **2,210,309,358.58** | **1,941,280,850.76** |
| 512 | Өмнөх үеийн үр дүн | 568,468,104.42 | 2,210,309,358.56 |
| 513 | Тайлант үеийн үр дүн / орон нутаг / | 1,641,841,254.16 | (269,028,507.80) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,958,806,674.58** | **2,996,283,850.73** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | **2023 оны 12 дугаар сарын 31** | **2024 оны 12 дугаар сарын 31** |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 122,455,284.38 | 134,636,444.01 |
| 2 | Борлуултын өртөг | - | - |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **122,455,284.38** | **134,636,444.01** |
| 8 | Татаас санхүүжилтийн орлого | 5,621,434,480.00 | 13,797,778,192.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,919,621,704.20 | 14,179,283,712.18 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **1,824,268,060.18** | **(246,869,076.17)** |
| 19 | Орлогын татварын зардал | 182,426,806.02 | 22,159,431.63 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **1,641,841,254.16** | **(269,028,507.80)** |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 1,641,841,254.16 | (269,028,507.80) |
| **24** | **Орлогын нийт дүн** | **1,641,841,254.16** | **(269,028,507.80)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл** | **565,955,000.00** | **568,468,104.42** | **1,134,423,104.42** |
| 2 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | **-** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **565,955,000.00** | **568,468,104.42** | **1,134,423,104.42** |
| 7 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 172,780,000.00 | - | **172,780,000.00** |
| 8 | Тайлант үеийн үр дүн | - | 1,641,841,254.16 | **1,641,841,254.16** |
| **11** | **2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл** | **738,735,000.00** | **2,210,309,358.58** | **2,949,044,358.58** |
| 12 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | (0.05) | **(0.05)** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **738,735,000.00** | **2,210,309,358.53** | **2,949,044,358.53** |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 316,268,000.00 | | **316,268,000.00** |
| 17 | Тайлант үеийн ашиг, алдагдал | | (269,028,507.80) | **(269,028,507.80)** |
| **19** | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,055,003,000.00** | **1,941,280,850.73** | **2,996,283,850.73** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **5,749,089,464.38** | **13,932,414,636.01** |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 5,621,434,480.00 | 13,797,778,192.00 |
| | Бусад мөнгөн орлого | 127,654,984.38 | 134,636,444.01 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **4,875,736,525.48** | **13,535,682,976.93** |
| | Ажиллагчдад төлсөн | 849,627,299.50 | 1,839,928,474.99 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 123,020,524.09 | 262,155,011.69 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 5,048,510.00 | 7,676,272.50 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 31,491,245.16 | 61,446,836.76 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 189,135,142.00 | 369,905,387.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 210,478,530.45 | 22,159,431.63 |
| | Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | 614,925.00 | 740,175.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 3,466,320,349.28 | 10,971,671,387.36 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **873,352,938.90** | **396,731,659.08** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **2.1** | **Мөнгө орлогын дүн (+)** | **-** | **-** |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **734,851,050.00** | **66,742,500.00** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 734,851,050.00 | 66,742,500.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **- 734,851,050.00** | **329,989,159.08** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **-** |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **-** | **-** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **138,501,888.90** | **329,989,159.08** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 30,701,037.08 | 169,202,925.98 |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **169,202,925.98** | **499,192,085.06** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/мян.төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2023 оны гүйцэтгэл | 2024 оны төлөвлөгөө | 2024 оны гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Нийт орлого** | | | **5,743,889.8** | **13,246,914.0** | **13,932,414.6** | **685,500.6** | 105.2 |
| 1.1 | Нийтлэг бус татварын орлого | | мян/ төг | 20,000.0 | 40,000.0 | 40,000.0 | - | 100.0 |
| 1.3 | Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | | мян/ төг | 5,621,434.5 | 13,206,914.0 | 13,797,778.2 | 590,864.2 | 104.5 |
| 1.5 | Бусад орлого | | мян/ төг | 102,455.3 | - | 94,636.4 | 94,636.4 | |
| **2** | **Нийт зардал** | | мян/ төг | **3,919,621.7** | **13,206,914.0** | **14,179,283.7** | **(246,869.1)** | 107.4 |
| 2.1 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | мян/ төг | | | | - | |
| 2.2 | 2.2.1 | Цалин | мян/ төг | 849,627.3 | 2,051,581.6 | 1,863,660.3 | (187,921.2) | 90.8 |
| | 2.2.2 | НДШ | мян/ төг | 123,020.5 | 297,479.1 | 262,145.4 | (35,333.7) | 88.1 |
| | 2.2.3 | Байр ашиглалттай холбоотой зардал | мян/ төг | 31,612.9 | 70,000.0 | 56,446.8 | (13,553.2) | 80.6 |
| | 2.2.4 | Бичиг хэрэг | мян/ төг | 4,540.8 | 18,241.2 | 7,352.3 | (10,888.9) | 40.3 |
| | 2.2.5 | Тээвэр, шатахуун | мян/ төг | 98,512.0 | 296,430.0 | 201,272.2 | (95,157.8) | 67.9 |
| | 2.2.6 | Шуудан холбоо | мян/ төг | 2,990.2 | 6,000.0 | 4,484.9 | (1,515.1) | 74.7 |
| | 2.2.7 | Хог хаягдал зайлуулах хортон мэрэгч устгах | мян/ төг | 413.0 | - | - | - | |
| | 2.2.8 | Сэлбэг хэрэгсэл | мян/ төг | 96,797.5 | 177,796.6 | 82,081.4 | (95,715.2) | 46.2 |
| | 2.2.9 | Засвар үйлчилгээний зардал | мян/ төг | 1,114,461.5 | 4,508,244.7 | 4,986,983.8 | 478,739.1 | 110.6 |
| | 2.2.11 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | мян/ төг | - | 15,990.3 | 15,801.0 | (189.3) | 98.8 |
| | 2.2.12 | Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | мян/ төг | 480.0 | - | - | - | |
| | 2.2.13 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | мян/ төг | 4,950.0 | 33,197.0 | 26,848.3 | (6,348.7) | 80.9 |
| | 2.2.15 | Тоног төхөөрөмж | мян/ төг | 215,031.3 | 42,599.5 | 25.0 | (42,574.5) | 0.1 |
| | 2.2.16 | Тавилга | мян/ төг | - | 20,506.0 | - | (20,506.0) | - |
| | 2.2.17 | Томилолтын зардал | мян/ төг | - | 25,000.0 | 10,027.9 | (14,972.1) | 40.1 |
| | 2.2.18 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | мян/ төг | 1,179,275.7 | 5,481,509.7 | 6,291,860.2 | 810,350.5 | 114.8 |
| | 2.2.19 | Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох | мян/ төг | 2,500.0 | 2,500.0 | 3,000.0 | 500.0 | 120.0 |
| | 2.2.20 | Даатгалын үйлчилгээ | мян/ төг | 614.9 | 1,500.0 | 740.2 | (759.8) | 49.3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.21 | Тээврийн хэрэгслийн татвар | мян/ төг | 726.5 | 1,500.0 | 869.5 | (630.6) | 58.0 |
| | 2.2.22 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | мян/ төг | 132.0 | 700.0 | 132.0 | (568.0) | 18.9 |
| | 2.2.24 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | мян/ төг | 391.3 | 500.0 | 410.9 | (89.1) | 82.2 |
| | 2.2.25 | Ерөнхий ба удирдлагын зардал | мян/ төг | 58.5 | - | 4,300.0 | 4,300.0 | - |
| | 2.2.27 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | мян/ төг | 590.0 | 4,550.0 | 3,800.0 | (750.0) | 83.5 |
| | 2.2.28 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | мян/ төг | 27,785.0 | 50,000.0 | 39,381.3 | (10,618.7) | 78.8 |
| | 2.2.29 | Бусад зардал | мян/ төг | 165,110.8 | 101,088.3 | 317,660.4 | 216,572.1 | 314.2 |
| | **Үйл ажиллагааны зардал** | | **мян/ төг** | **3,919,621.7** | **13,206,914.0** | **14,179,283.7** | **972,369.7** | **107.4** |
| 3 | Татвар төлөхийн дараах ашиг алдагдал | | мян/ төг | 1,824,268.1 | 40,000.0 | (246,869.1) | (286,869.1) | - |
| 4 | Орлогын татвар | | мян/ төг | 182,426.8 | - | 22,159.4 | 22,159.4 | - |
| **5** | **Цэвэр ашиг алдагдал** | | мян/ төг | **1,641,841.3** | **40,000.0** | **(269,028.5)** | **(309,028.5)** | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 124,704.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланг төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэн ирүүлсэн, Мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйлгээний эхний үлдэгдэл 734,851.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үзүүлэлтүүд дутуу тайлагнагдсан байна. | 1 | 614,641.9 | - | - | 1 | 614,641.9 | 1 | 614,641.9 | - | - | - | - |
| Үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнгээс НӨАТ-ын тайлангийнх 365,997.6 мянган төгрөгөөр дутуу, Санхүү байдлын тайлангийн НӨАТ-ын авлагын дүнгээс 248,644.3 мянган төгрөгөөр /илүү/ зөрүүтэй тайлагнагдсан байна. | 1 | 27,983.6 | - | - | 1 | 27,983.6 | 1 | 27,983.6 | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгөд 162.5 мянган төгрөгийн элэгдэл илүү байгуулснаас хөрөнгийн эцсийн үлдэгдэл хасах утгатай болсон, зарим хөрөнгийн тайлант оны элэгдлийн дүн дутуу тооцоолгдсоноос үндсэн хөрөнгийн үлдэгдэл 27,983.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна. | 1 | 734,851.0 | - | - | 1 | 734,851.0 | 1 | 734,851.0 | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **1,377,476.5** | **-** | **-** | **3** | **1,377,476.5** | **3** | **1,377,476.5** | **-** | **-** | **-** | **-** |

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Татварын цахим системд худалдан авалтын 124,704.5 мянган төгрөгийн и баримт бүртгэгдээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 124,704.5 | - | - | - | - | - | - | 1 | 124,704.5 | - | - |
| 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын17-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **124,704.5** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **1** | **124,704.5** | **-** | **-** |